



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 18.

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"ХЭЛЭЛЦСЭН нь: Авлагад тооцон хөрөнгө хүлээн авах тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газар "Талст бластинг консалтинг" ХХК-ийн хооронд "Ажил гүйцэтгэх гэрээг" 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал 3 сарын хугацаатай байгуулсан бөгөөд 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дуустал сунгасан байна.

Дээрх гэрээний дагуу "Эрдэнэт үйлдвэр" үйлдвэрийн газар нь "Талст бластинг консалтинг" ХХК-ийн Өмнөговь аймаг Ханхонгор сумын нутагт байрлах уурхайн төслийн талбайд тэсэлгээний цооног өрөмдөж нийт 782,469,762.94 (долоон зуун наян хоёр сая дөрвөн зуун жаран есөн мянга долоон зуун жаран хоёр төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн ажил гүйцэтгэсэн.


"Талст бластинг консалтинг" ХХК "Ковид-19 цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан санхүүгийн хүндрэлд орсон гэх шалтгаанаар 2017-2018 онд гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлж барагдуулаагүй байгаа учир хугацаа хэтэрсэн авлагад тооцон суудлын автомашинуудыг /3 ширхэг/ шилжүүлэн өгөх хүсэлт гаргажээ.

"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газраас 2021 оны ТБ 111-12/4346 дугаар албан бичгээр "Талст бластинг консалтинг" ХХК-иас авах авлагаа барагдуулахын тулд тээврийн хэрэгслийг авах зөвшөөрөл олгох тухай хүсэлтийг ирүүлсэн

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

"Талст бластинг консалтинг" хязгаарлагдмал хариуцлагатай компаниас хугацаа хэтэрсэн авлагад тооцон суудлын автомашинуудыг хөрөнгийн үнэлгээ, чанар байдлыг нягтлан хүлээн авч, тооцоо нийлэн хөрөнгийн бүртгэлд тусгахыг "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газарт зөвшөөрөв" гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



13201050

6000100 1110202023 \Huraldaanii material\2021 on\2021.08.12 13-r huraldaan.docx